



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 02

Номгон

Төрийн болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа, ил тод нээлттэй байдлын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хангалтгүй байна.

Сум, агентлагуудаас ирж буй тайлангуудын хэрэгжилт хангалтгүй, ирүүлбэл зохих бодлогын болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг дутуу, хугацаа хожимдож ирүүлдэг, зохих журмыг баримтлан шалгуур үзүүлэлт, суурь болон хүрсэн төвшинтэй харьцуулан бодит үр дүнгээр тайлагнадаггүй зэрэг нийтлэг зөрчил, дутагдал гарсан нь төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлага, бие биедээ тавих зарчимч шаардлага, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо суларсантай холбоотой гэж үзэн Төрийн болон орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөө, төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлага, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

**1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, холбогдох хэлтсийн дарга нарт**

1.1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн заалт бүрийг хяналтад авч сумдын Засаг даргын Тамгын газар, агенлагуудын хяналтад авахуулж, тайлан ирүүлэхэд хяналтад байгаа тогтоол, шийдвэрийг бүрэн ирүүлж буй эсэхэд тавих дотоодын хяналтыг шинэ шатанд гаргах;

1300125

## 2.

1.2.Засаг даргын Тамгын газрын хэлтэс, эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын ажлын уялдаа холбоо, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэн ажиллах;

1.3.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/142 дугаар захирамжаар батлагдсан “Бодогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг төрийн албан хаагчдад судлуулах, сургалт зохион байгуулах;

1.4.Сум, агентлагуудаас ирсэн бодлогын баримт бичиг болон тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайланд бодлогын хэлтсүүд боловсруулалт хийх ажлыг тогтмолжуулах;

1.5.Сум, агентлагуудад бодлогын баримт бичиг болон Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаар зөвлөн туслах ажлыг тогтмол хийх;

1.6.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн таван жилийн төлөвлөгөө, үндэсний болон дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад бодлогын хэлтэс, сумдын Засаг даргын Тамгын газар, агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан нэг цэгт төвлөрүүлэн ажиллах;

1.7.Аймгийн стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах;

1.8.Ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн хугацаанд тавих хяналтыг өндөржүүлэх;

1.9.Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран 2021 онд багтаан хэрэгжүүлэх;

1.10.Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэхтэй холбогдуулан мэдээллийн суурь бааз бэлтгэх, төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

### **2.Сумдын Засаг дарга, агентлагийн дарга нарт**

2.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай, үнэлгээ бууруулан дүгнэсэн арга хэмжээнүүдийг эрчимжүүлэн ажиллах;

2.2.Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын “Аргачлал, загвар батлах тухай” 2020 оны 100 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны А/142 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль

3.

тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг төрийн албан хаагчдаар судлуулан хэрэгжилтийг зохион байгуулах;

2.3.Төрийн албан хаагчдын үүрэг, хариуцлага, ажлын уялдаа холбоог сайжруулан, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцож Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст ирүүлэх;

2.4.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4-р бүлгийн 4.1, 4.3, 4.4, 4.5, 4.6, 4.6.1, 4.6.2, 4.6.3 заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/142 дугаар захирамжийн хэрэгжилтийг 09 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулж дүнг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлэх;

2.5.Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэхтэй холбогдуулан мэдээллийн суурь бааз бэлтгэх, төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

2.6.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах;

3. Сум, агентлагийн 2021 оны жилийн эцсийн Бодлогын баримт бичиг болон Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаа, ил тод байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гарсан ахиц өөрчлөлтийн талаар тайлагнахын зэрэгцээ хариуцлагагүй хандсан сумдын Засаг дарга, хэлтэс, агентлагийн дарга нарт хариуцлага тооцуулах саналаа Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Мандал)-д үүрэг болгосугай.

4. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь) -д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН